



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Журам, загвар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны “Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа тодорхойлолт олгох журам”-ыг нэгдүгээр, тодорхойлолтын загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Боловсролын салбарын мэдээллийн системээс “Хур” системтэй холбогдох сервис үүсгэх, холбогдох журмын дагуу “Үндэсний дата төв”-тэй гэрээ байгуулах ажлыг зохион байгуулахыг Мэдээллийн технологи, статистикийн хэлтэс /О.Дүнжиннамдаг/, Боловсролын мэдээллийн технологийн төв /Ц.Тодгэрэл/-д тус тус үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Г.Энхжаргал/-т даалгасугай.

САЙД



Л.ЦЭДЭВСҮРЭН

142110031

Боловсрол, шинжлэх ухааны  
сайдын 2021 оны 01-р сарын 15-ний өдрийн  
№9 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД  
СУРАЛЦАЖ БАЙГАА ТОДОРХОЙЛОЛТ  
ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургууль, коллежид суралцаж байгаа эсэх талаарх лавлагаа, тодорхойлолтыг /цаашид, тодорхойлолт гэх/ иргэний хүсэлтээр цахимаар олгоход энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2 Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/265 дугаар тушаалаар батлагдсан “Боловсролын салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”-ын дагуу тодорхойлолт дахь мэдээллийг бүрдүүлнэ.
- 1.3 Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 220 дугаар тогтоолоор баталсан “Төрийн байгууллагаас төрийн болон орон бусад байгууллагатай цахим хэлбэрээр мэдээлэл солилцох, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам”-ын дагуу тодорхойлолт мэдээллийг цахимаар солилцоно.

Хоёр. Тодорхойлолт олгох

Боловсролын салбарын мэдээллийн систем /цаашид “мэдээллийн систем” гэх/-аас тодорхойлолтын мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны “ХУР” систем ашиглан Төрийн үйлчилгээний цахим машин болон Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /цаашид “E-mongolia.mn” гэх/ Боловсрол цэсний “Суралцаж буй тодорхойлолт” үйлчилгээ хэсэгт байршуулна.

- 2.1 Тодорхойлолт олгохтой холбоотой мэдээлэл солилцооны цахим шийдлийг “Боловсролын мэдээллийн технологийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газар, “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газартай байгуулсан гэрээгээр зохицуулна.
- 2.2 Тодорхойлолтыг иргэнд төрийн үйлчилгээний цахим машин болон төрийн үйлчилгээний нэгдсэн системээс тус тус олгоно.
- 2.3 Тодорхойлолтыг иргэнд үнэ төлбөргүй олгоно. Төрийн үйлчилгээний цахим машинаас авах тохиолдолд 500 төгрөгийн үйлчилгээний хураамжийг Үндэсний дата төвд төлнө.
- 2.4 Тодорхойлолт нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан ёсны баримт бичиг байна.
- 2.5 Тодорхойлолт нь түүнийг олгосон өдрөөс хойш 30 хоног хүчинтэй байна.
- 2.6 Төрийн үйлчилгээний цахим машин болон төрийн үйлчилгээний нэгдсэн системээс олгож байгаа тодорхойлолт нь бар код, тэмдэгтээр баталгаажна.

2.7 Тодорхойлолтын мэдээллийн сангийн програм хангамж, техник технологи, мэдээллийн аюулгүй байдал болон нууцлалын, асуудалд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын статистик, мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж хяналт тавина.

2.8 Тодорхойлолт дахь мэдээлэл зөрүүтэй, алдаатай гарснаас үүсэх асуудлыг тухайн сургалтын байгууллагын захирал, эрхлэгч хариуцна.

\_\_\_o0o\_\_\_



Боловсрол, шинжлэх ухааны сайдын  
2021 оны ... сарын ... -ний өдрийн  
А/... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Лавлагаа-1

## СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД СУРАЛЦАЖ БАЙГАА ТОДОРХОЙЛОЛТ

Монгол улсын иргэн ..... регистрийн дугаартай  
..... овогтой..... нь .....-..... оны хичээлийн жилд  
.....-ийн  
..... бүлэгт сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байгаа болно.

Энэхүү тодорхойлолт нь Монгол улсын сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байгааг гэрчилсэн баримт бичиг мөн болно.

### БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

QR код

Лавлагааны хүчинтэй хугацаа 30 хоног

Энэхүү лавлагааны хүчинтэй эсэхийг

<https://tutsmashin.gov.mn/> болон <https://www.esis.edu.mn> -ээс шалгах боломжтой.

\_\_\_о0о\_\_\_



Боловсрол, шинжлэх ухааны сайдын  
2021 оны ... сарын ... -ний өдрийн  
А/... дугаар тушаалын хоёрдугаар хэвсрэлт

Лавлагаа-2

**ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД  
СУРАЛЦАЖ БАЙГАА ТОДОРХОЙЛОЛТ**

Монгол улсын иргэн ..... регистрийн дугаартай  
..... овогтой..... нь .....-..... оны хичээлийн жилд  
.....-ийн  
.... -р ангид суралцаж байгаа болно.

Энэхүү тодорхойлолт нь Монгол улсын ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгааг гэрчилсэн баримт бичиг мөн болно.

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ**

QR код

Лавлагааны хүчинтэй хугацаа 30 хоног  
Энэхүү лавлагааны хүчинтэй эсэхийг

<https://tutsmashin.gov.mn/> болон <https://www.esis.edu.mn> -ээс шалгах боломжтой.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын  
2021 оны ... сарын ... -ний өдрийн  
А/... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



Лавлагаа-3

## ИХ, ДЭЭД СУРГУУЛЬ, КОЛЛЕЖИД СУРАЛЦАЖ БАЙГАА ТОДОРХОЙЛОЛТ

Монгол улсын иргэн ..... регистрийн дугаартай  
..... овогтой..... нь .....-..... оны хичээлийн жилд  
..... -д  
..... мэргэжлийн чиглэлээр ..... онд элсэж  
..... түвшинд суралцаж байгаа болно.

Энэхүү тодорхойлолт нь Монгол улсын их, дээд сургууль, коллежид суралцаж байгааг гэрчилсэн баримт бичиг мөн болно.

## БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

QR код

Лавлагааны хүчинтэй хугацаа 30 хоног

Энэхүү лавлагааны хүчинтэй эсэхийг

<https://tutsmashin.gov.mn/> болон <https://www.esis.edu.mn/> -ээс шалгах боломжтой.

\_\_\_оОо\_\_\_